



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 699

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн бирж”  
төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай  
компанийн нэмж гаргасан хувьцааг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 тоот тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 330 тоот тогтоолыг тус тус үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэмж гаргасан 106,350,000 (Нэг зуун зургаан сая гурван зуун тавин мянга) ширхэг энгийн хувьцааг компанид технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтэд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдад 2015 оны дөрөвдүгээр улиралд багтаан нэг бүрийг нь 90 төгрөгөөс доошгүй үнээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. “Нэмэлт хувьцаа гаргах хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Хувьцаа худалдах журам”-ыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Хувьцаа худалдах ажиллагааг Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хуульд нийцүүлэн энэхүү тогтоолоор баталсан “Нэмэлт хувьцаа гаргах хөтөлбөр”, “Хувьцаа худалдах журам”-ын дагуу зохион байгуулж, компанийн нэмэлт хувьцааг худалдан авагчтай “Худалдах, худалдан авах гэрээ” болон “Хувьцаа эзэмшигчдийн хооронд хамтран ажиллах гэрээ”-г тус тус байгуулахыг Бүтцийн өөрчлөлт, хувьчлалын газар /Д.Эрэвгийлхам/-т даалгасугай.

4. Компанийн тухай хуульд заасан журмын дагуу 2016 оны эхний хагаст багтаан төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд хувьцаа нэмж гарган худалдахыг “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

5. Компани шинээр хувьцаа гаргасантай холбогдуулан хөрөнгө оруулагч нартай хувьцаа худалдах худалдан авах гэрээг байгуулах, нэмэлт хувьцаа гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг компанийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.НАНЗАДДОРЖ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Х.ВОЛОДЯ

